

Төгсөв
24/15

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2017 ОНЫ ТАЙЛАН

НЭГ. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хууль, заавар журмыг хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавин ажилласнаар 2016 оны Үндэсний аудитын газрын санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын шалгалтаар санхүүгийн үйл ажиллагаа хэвийн зөрчилгүй дүгнэлт авсан. Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн шууд захирагч агентлаг, байгууллагуудаас Санхүү, Төсөв, Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаагаар 2 жил дараалан манлайлан тэргүүлсэн.

Санхүүгийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээг тогтоосон хугацаанд байгуулж, бүрэн хэрэгжүүлэн ажилласан.

2017 оны 1,2,3 дугаар улирлын санхүүгийн тайлан тэнцлийг хуулийн хугацаанд гаргаж Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэнээр хянан баталгаажуулж, Сангийн яамны Э-тайланд цахим хэлбэрээр шивж оруулсан ба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийг баримтлан, бүх төрлийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн давхар бичилтийн зарчмаар бүртгэсэн ба хөрөнгийг нэрлэсэн үнээр нь болон анхны өртгөөр нь үнэлж, хөрөнгөнд элэгдэл байгуулан элэгдлийн зардлыг бүртгэсэн.

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон их сургуулийн мөнгөн кассын сахилга батыг чандлан сахиж, гүйлгээг анхан шатны бүрдэл болсон баримтаар хийж, үлдэгдлийг өдөр тутам гаргуулж, байвал зохих бэлэн мөнгөний хэмжээг 14 хоног тутам тоолж, хяналт тавин удирдлагад танилцуулж хэвшсэн ба “Жижиг мөнгөн сан”-д тогтмол дүүргэлт хийж, тайланг тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн сангаар хянуулж баталгаажуулан ажилласан.

Бараа материал, мөнгөн хөрөнгийн тайланг хариуцсан нярав нар сар бүр гаргаж, нягтлан бодогч анхан шатны баримтуудтай тулгалт хийж шалган хүлээн авч агуулахын бүртгэлийг баталгаажуулж ажилласан. Мөн хөрөнгийн хөдөлгөөн гарсан тухай бүрт эд хариуцагчийн карт, тээврийн хэрэгсэл, барилгын хувийн хэрэг, техник тоног төхөөрөмжийн паспортын хөтлөлтийн баяжуулалтыг санхүүгийн тайлантай тулгалт хийж хянаж хэвшсэн.

Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, өр, авлагын мэдээг хугацаанд нь гарган Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яамны Төрийн сангийн газарт тус тус хянан баталгаажуулан өгсөн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/28, А/116, А269 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын хүрээнд 2017 онд улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-ний дагуу Их сургуулийн захирлын тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан ба уг үнэлгээний хороо худалдан авалтыг зохион байгуулж явуулахдаа бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас үнийн судалгаа авч харьцуулалтын аргаар бэлтгэн нийлүүлэгчийг

Улс орны эдийн засгийн бодлогын хүрээнд төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой шинжлэх ухааны техникийн ололтыг нэвтрүүлж, технологийн өөрчлөлт хийж 800,0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосноор нэн шаардлагатай зардлыг санхүүжүүлэх тооцоо судалгаа, үнэлгээ хийж удирдлагад танилцуулснаар зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах саналаа Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд хүргүүлснээр 4 удаа төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж батлуулан хэрэгжүүлж байна.

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлтийн байдал

/мян.төг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Эрх зүйн оюутны сургалтын төлбөр	187 500,0	357 525,5	190,7
2	Дамжаа, харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтын төлбөр	40 625,0	101 215,0	249,3
4	Магистрийн сургалтын төлбөр	232 500,0	215 879,7	92,9
5	Докторантурын сургалтын төлбөр	12 917,0	7 686,0	59,7
	Үндсэн үйл ажиллагааны дүн	473 542,0	682 306,2	144,1
6	Хичээл нөхөлтийн орлого	208,0		
7	Дахин шалгалтын орлого	583,3	1 430,3	245,2
8	Бусад орлого	4 000,0	9 806,4	245,2
9	Хэвлэхийн орлого	125,7	514,5	409,3
	Үндсэн бус үйл ажиллагааны дүн	4 917,0	11 751,2	238,9

Хууль сахиулахын их сургуулийн үндсэн үйл ажиллагааны орлого нь сургалтын төлбөрийн орлогоос бүрддэг бөгөөд 2017 онд Эрх зүйн төлбөртэй ангид 100 оюутан авахаар төлөвлөсөн ч элсэлтийн журамд өөрчлөлт орсоноор 180 оюутан эслүүлсэн, мөн харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтанд хамрагсадын тоо төлөвлөсөн хэмжээнээс 90 хүнээр нэмэгдсэн зэрэг шалтгаанаас орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.

Өөрийн үйл ажиллагааны орлого бүрдсэн байдал



Туслах үйл ажиллагааны орлого нь хэвлэх, дахин шалгалт, тодорхойлолт, хувцасны төлбөр тооцоо зэргээс бүрддэг бөгөөд 2017 онд сурлага, сахилгаар хасагдсан сонсогчдын хувцасны төлбөр нь орлогын төлөвлөгөө давах гол шалтгаан болсон байна.

Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн бөгөөд үүний 98,3 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого эзэлж байна.

ГУРАВ. ТӨСВИЙН ЗАРЛАГА

Хууль сахиулахын их сургуулийн 2017 оны 10-р сарын төсвийн гүйцэтгэл

Зардлын зүйл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Бусад байгууллага иргэдээс авах авлагын эхний үлдэгдэл	-	27,932,424.00		
Бусад байгууллага иргэдэд өгөх өглөгийн эхний үлдэгдэл	-			
I. ОРЛОГЫН ДҮН	9,339,165,700.00	9,462,515,280.00	(123,349,580.00)	101.3
Төсвөөс урсгал санхүүжилт	8,860,706,700.00	8,768,457,900.00	92,248,800.00	99.0
Үндсэн үйл ажиллагааны орлого	473,542,000.00	682,306,200.00	(208,764,200.00)	144.1
Туслах үйл ажиллагааны орлого	4,917,000.00	11,751,180.00	(6,834,180.00)	239.0
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	9,339,165,700.00	8,143,686,640.64	1,195,479,059.36	87.2
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	9,339,165,700.00	8,143,686,640.64	1,195,479,059.36	87.2
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,993,165,700.00	7,887,709,140.64	1,105,456,559.36	87.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,097,569,000.00	5,092,311,369.00	5,257,631.00	99.9
Үндсэн цалин	3,351,615,200.00	3,347,028,337.00	4,586,863.00	99.9
Нэмэгдэл	1,554,725,400.00	1,554,054,632.00	670,768.00	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	191,228,400.00	191,228,400.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл	158,841,600.00	142,246,107.00	16,595,493.00	89.6
Тэтгэврийн даатгал	26,836,400.00	38,250,831.00	(11,414,431.00)	142.5
Тэтгэмжийн даатгал	3,833,400.00	3,454,000.00	379,400.00	90.1
ҮОМШӨвчний даатгал	3,066,600.00	2,763,000.00	303,600.00	90.1
Ажилгүйдлийн даатгал	768,200.00	693,100.00	75,100.00	90.2
Эрүүл мэндийн даатгал	124,337,000.00	97,085,176.00	27,251,824.00	78.1
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	752,452,800.00	449,950,842.04	302,501,957.96	59.8
Гэрэл, цахилгаан	232,452,800.00	192,978,668.00	39,474,132.00	83.0
Түлш, халаалт	320,000,000.00	175,298,978.40	144,701,021.60	54.8
Цэвэр, бохир ус	200,000,000.00	81,673,195.64	118,326,804.36	40.8
Хангамж бараа материалын зардал	154,468,900.00	150,627,785.77	3,841,114.23	97.5
Бичиг хэрэг	16,536,000.00	16,417,300.00	118,700.00	99.3
Тээвэр шатахуун	57,616,900.00	54,134,125.00	3,482,775.00	94.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,193,000.00	20,166,175.77	26,824.23	99.9

ном хөдлэл	32,752,000.00	33,129,600.00	(377,600.00)	101.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,371,000.00	26,780,585.00	590,415.00	97.8
Нормативт зардал	1,834,187,600.00	1,129,475,296.50	704,712,303.50	61.6
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,376,600.00	18,118,473.00	(9,741,873.00)	216.3
Хоол хүнс	950,000,000.00	592,659,920.00	357,340,080.00	62.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	875,811,000.00	518,696,903.50	357,114,096.50	59.2
Эд хогшил, урсгал засварын зардал	475,488,100.00	475,487,089.00	1,011.00	100.0
Багаж техник хэрэгсэл	205,488,100.00	181,330,330.00	24,157,770.00	88.2
Урсгал засвар	90,000,000.00	46,634,126.00	43,365,874.00	51.8
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	180,000,000.00	247,522,633.00	(67,522,633.00)	137.5
Томилолт, зочний зардал	18,000,000.00	12,732,796.00	5,267,204.00	70.7
Дотоод албан томилолт	18,000,000.00	12,732,796.00	5,267,204.00	70.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	159,278,900.00	111,248,749.33	48,030,150.67	69.8
Эрдэм шинжилгээ	58,000,000.00	26,386,700.00	31,613,300.00	45.5
Холбооны суваг	7,231,000.00	6,508,361.33	722,638.67	90.0
Даатгалын үйлчилгээ	9,031,900.00	9,023,188.00	8,712.00	99.9
Тээврийн хэрэгслийн татвар	2,725,700.00	2,725,700.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	290,300.00	290,300.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	82,000,000.00	66,314,500.00	15,685,500.00	80.9
Бараа үйлчилгээний бусад зардал	342,878,800.00	323,629,106.00	19,249,694.00	94.4
Бараа үйлчилгээний бусад зардал /БТ/	12,878,800.00	9,336,300.00	3,542,500.00	72.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	330,000,000.00	314,292,806.00	15,707,194.00	95.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	346,000,000.00	255,977,500.00	90,022,500.00	74.0
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	16,000,000.00	15,977,500.00	22,500.00	99.9
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	330,000,000.00	240,000,000.00	90,000,000.00	72.7
Бусад байгууллага иргэдээс авах авлагын эцсийн үлдэгдэл	-	72,192,600.00		
Бусад байгууллага иргэдэд өгөх өглөгийн эцсийн үлдэгдэл	-			



Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу цалингийн программаар сар бүрийн 10,25-нд цалинг бодож, цалингийн тооцооны баримтыг хүн бүрээр хэвлэн гаргаж гарын үсэг зуруулан олгосон.

Цалингаас суутгаж байгаа ХАОАТ, НДШ-ийн тооцоо, тайланг Баянзүрх дүүргийн Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэст хуулийн хугацаанд гарган өгч хэвшсэн ба эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын дэвтрийн хөтлөлтийг хийж, сар бүр баталгаажуулсан. Мөн их сургуулийн сонсогч оюутан нарын цолны цалинг сар бүр ирүүлсэн ирцийн тодорхойлолт, тушаалын дагуу бодож сонсогч бүрийн харилцах дансанд нь шилжүүлэн олгосон.



2017 оны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн гүйцэтгэл өнгөрсөн онтой харьцуулахад 245,1 сая төгрөгөөр өссөн нь Монгол улсын Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоосонтой холбоотой бөгөөд алба хаагчдын сарын дундаж цалин 4 хувиар өссөн байна.

Алба хаагч нарын сарын дундаж цалин



Их сургуулийн 2017 оны батлагдсан төсвийн 5,5 хувийг эзэлдэг байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 449,9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан ба үүний 42,9 хувийг гэрэл цахилгаан, 38,9 хувийг түлш халаалт, 18,2 хувийг цэвэр бохир усны зардал тус тус эзэлж байна.

Тогтмол зардал /сая.төг/



2016 оны 5 дугаар сард 3000 сонсогчийн хичээлийн байрыг ашиглалтанд оруулсанаар байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2016 оны мөн үеийн гүйцэтгэлээс 29,2 сая төгрөгөөр нэмэгдсэн. Мөн 2016 оны 3-р улиралд гэрэл, цахилгааны тариф нэмэгдсэний улмаас нийт тогтмол зардлын дүн 2016 оны гүйцэтгэлээс 9,1 сая төгрөгөөр өссөн байна.

Сургалтын орчинг сайжруулах, техник хэрэгслээр хангах, алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар

Их сургууль болсонтой холбоотой багш, сонсогч оюутны тоо нэмэгдсэн, 3000 сонсогчийн хичээлийн байр ашиглалтанд орсонтой холбоотой орчин үеийн хүчин чадал сайтай техник хэрэгсэл, ширээ сандал зайлшгүй шаардлагатай байсан. Иймээс 92,5 сая төгрөгийн сургалтын техник хэрэгсэл, 157,8 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 43,4 сая төгрөгийн ном, сурах бичиг тус тус худалдан авч сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Улс орны эдийн засгийн хямрал, төсвийн хөрөнгийн нөөц, боломжоос хамаарч шаардлагатай түвшинд хүртэл техник хэрэгслийн хэрэгцээ шаардлага хангагдахгүй байна.

**Техник, тоног төхөөрөмж
/төгрөгөөр/**



Цахим сургууль болох зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Мэдээлэл технологи, холбооны хэлтэстэй хамтран төсөл боловсруулан 2016-2018 оны төсвийн төсөл, төсөөлөлд саналаа хүргүүлж, төсөв батлагдсны дагуу 2017 онд шаардлагатай техник хэрэгслийн хангалтыг хийж харуул хамгаалалтын камержуулалт, дотоод сүлжээ, хяналтын камержуулалтыг бүрэн хийсэн.

Хөрөнгийн бүртгэл хөтлөлт, цаг ашиглалт, хүний нөөц, хувцасны программыг санхүүгийн программтай холбох бэлтгэл ажлыг хангасан ба 4 программыг холбоход шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр дутагдалтай байгаа тул түр хугацаагаар хойшлогдоод байна. Нэгдсэн программтай болсноор алба хаагчийн мэдээлэлийн болон хөрөнгийн бүртгэл сайжирна. Цаг ашиглалтын программын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэснээр программын шинэчлэл хийгдэж хүний нүүрээр бүртгэдэг болж, цаг ашиглалтын үр дүнг нэмэгдүүлээд байна.

**Тавилга, эд хогшил
/төгрөгөөр/**



Их сургуулийн алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, туршлага судлах, судалгаа хийх үүднээс гадаад оронд 23 алба хаагчийг 66,2 сая төгрөгөөр, дотоодын сургалтад 157 алба хаагчийн 6,1 сая төгрөгөөр, нийт 72,3 сая төгрөгийн зардлыг байгууллага хариуцан хамруулсан.


Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс Их сургуулийн хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн 37 хүнд 11,5 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, 11 алба хаагчид цэргийн өндөр насны тэтгэвэрт гарахад нь олгох тэтгэмжид 316,9 сая төгрөгийг их сургуулийн захирлын тушаалаар тус тус олгосон.



Их сургуулийн эрдэмтэн, доктор, багш, алба хаагч, нарын бүтээсэн эмхэтгэлүүд, 1105 ширхэг 28,1 сая төгрөгийн номыг худалдан авч хуваарийн дагуу тараан олгож, санхүүгийн тайлан тэнцэлд тусгаж номын фондыг нэмэгдүүлснээр багш, алба хаагч, сонсогч нарыг шаардлагатай ном сурах бичгээр хангаж байна. Мөн албан байгууллага, хувь хүмүүс, эрдэмтэн багш нараас 8755 ширхэг 15,3 сая төгрөгийн ном хандивласаныг орлогод авч үнэн зөв тайлагнаснаар их сургуулийн хэмжээнд 70541 ширхэг номтой болоод байна.

Гүнжийн хоолой дахь сургалтын дадлагын төвд 10 контейнер худалдан авч 5 сууц болгон барих, ундны усны ундарга муу тул гүний худаг гаргуулах, сонсогч ор, түүнд суурилагдах зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмжийг худалдан авах санхүүгийн эх үүсвэрийг төсөвт зохицуулалт хийж бүрэн шийдвэрлэсэн ба хөрөнгийг холбогдох данс бүртгэлд тусган авч, эд хариуцагчийн картанд бүртгэн хээрийн сургалтын төвийн харуулд хүлээлгэн өгсөн. Хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд ажлын шаардлагаар болон гэнэтийн үзлэг шалгалт хийж зөрчлийг арилган ажилласан.

Хичээл үйлдвэрлэл, дадлага хийхэд 456,3 сая төгрөг, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийхэд 41,0 сая төгрөг, ном хэвлэл авахад 28,1 сая төгрөг, нийт 525,4 сая төгрөгийг зарцуулж сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулж байна.



Хөрөнгө оруулалт

Их сургуулийн 3000 сонсогчийн хичээлийн төв байр 2016 онд ашиглалтанд орсонтой холбоотой түүнд суурилагдах 2,3 тэрбум төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийн тооцоо, үнийн судалгаа, танилцуулгыг гарган хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх саналаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн боловч 2017 оны хөрөнгө оруулалтын төсөвт мөнгө тусгагдаагүй, урсгал зардлын төсөвт 155,0 сая төгрөгийг багаж хэрэгслийн зардалд тусган батлуулсан байна. 2017 онд сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай лаборатори байгуулахад техник, тоног төхөөрөмж, хэрэгслийн тооцоо судалгааг гарган олон улсын байгууллагын төсөлд хамрагдахаар 2,0 сая долларын материалыг гарган Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.

2018 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд 3000 сонсогчийн хичээлийн байранд байрлах алба хаагч, сонсогчийн хоолны газрын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тооцоо, судалгааг тусгаснаар 63,9 сая төгрөгийг батлуулаад байна.

ДӨРӨВ. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл, Салбарын хөгжлийн бодлого, Их сургуулийн дунд болон хэтийн төлөвлөгөө, эрхэм зорилго, “Инновацийг нэвтрүүлж, эрдэм судлалыг дээдэлсэн цахим сургууль болно” зорилго, “Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх ажлыг эхлүүлж, сургалтын материаллаг бааз, холбоо, мэдээлэл, технологийн шинэчлэлийг хийх” зорилт зэрэгт тулгуурлан сургуулийн бүтцийн нэгжийн дарга нараас санал авч нэгтгэн, холбогдох хуулийн заалт, хэсгийг үндэслэн тус их сургуулийн 2018-2020 оны зарлагын төсвийн төслийг зардлын зүйл болон хөтөлбөрт суурилсан байдлаар төлөвлөн, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг хөтөлбөр тус бүрээр боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлж хянуулсны дагуу 2018 оны урсгал зардлын төсвийг 11,6 сая төгрөгөөр батлуулсан.

“Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгуулах 2018-2020 оны хөрөнгө оруулалтын төсөөлөлийг “Спорт цогцолбор”-ыг барих, түүнд суурилуулах тоног төхөөрөмжийн зардалд 12,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөөлөл, судалгаа, үр ашгийн тооцоог объект тус бүрээр /51 хуудас/ гарган Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсээр 63,9 сая төгрөгийг батлуулсан.

ТАВ. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 1-р сарын 18-ны өдрийн 17-р тогтоолоор баталсан “Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ын дагуу Их сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бие даасан байх, ил тод, нээлттэй байх зарчим дээр тулгуурлан өмнөх оны төсвийн гүйцэтгэл, 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь Сангийн яамны болон Их сургуулийн Шилэн дансанд цахим хэлбэрээр, санхүүгийн мэдээллийн самбарт цаасаар тухай бүр байрлуулсан.

Шилэн дансны тухай хууль, түүнийг дагаж мөрдөх журмыг хэрэгжүүлэх үүднээс тус их сургуулийн 2017 оны батлагдсан төсөв, 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авалт, 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 2017 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 5,0 сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрүүдийг холбогдох файлуудын хамт Сангийн яамны болон их сургуулийн шилэн данс, санхүүгийн мэдээллийн самбарт тухай бүр байршуулан олон нийтэд ил тод мэдээллэсэн.

Худалдан авах ажиллагааны тайланг хуулийн хугацаанд гарган Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн ба эх хувиар нь их сургуулийн www.leu.gov.mn веб сайт болон санхүүгийн мэдээллийн самбарт байршуулсан.

Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлуулан мөрдөн ажиллаж байна.

Монгол улсын “2017 оны Төсвийн тухай” хуулиар батлагдсан их сургуулийн 2017 оны төсвийг байгууллагын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулан гаргасан сарын хуваарь, 2017 оны төсвийн гүйцэтгэл, 2017-2019 оны төсвийн төсөөллийг Их сургуулийн www.leu.gov.mn веб сайт болон санхүүгийн мэдээллийн самбарт байршуулан сургуулийн бие бүрэлдэхүүнд тухай бүр мэдээлэл авах боломжоор хангасан.

Их сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2017 оны төсвийн гүйцэтгэлийн болон өглөг, авлагын мэдээ/байгууллага, хувь хүмүүс, алба хаагч нараар гарган/, улирал бүрийн санхүүгийн тайланг сургуулийн удирдлага, алба хаагч нарт ойлгогдох байдлаар санхүүгийн зардлыг бүлэглэн гаргаж их сургуулийн www.leu.gov.mn веб сайт болон санхүүгийн мэдээллийн самбарт байршуулан мэдээлж, хяналт тавих боломжоор ханган ажилласан.

Их сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар аудит хийсэн дүгнэлт, зөвлөмжийг бүрэн эхээр нь их сургуулийн www.leu.gov.mn веб сайт болон санхүүгийн мэдээллийн самбарт байршуулсан, мөн сургуулийн захирлын холбогдох удирдлагуудад танилцуулж цаашид авах арга хэмжээний талаар үүрэг даалгавар авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дотоод орчны шинжилгээ	
Давуу тал	Сул тал
- Нийт зардлын ихэнх хэсэг буюу 94,8 хувийг улсын төсвөөс санхүүждэг; - Одоогийн байршилд хичээлийн болон дотуур байр, спортын ордон зэрэг барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон буцалтгүй тусламжаар шинээр баригдах нөхцөл бүрдсэн нь бусад их, дээд сургуультай харьцуулахад цогцолбор хэлбэрээр баригдаж байгаа тул төсвийг үр ашигтай зарцуулах боломжтой; - Сургалт, эрдэм шинжилгээ явуулах сургалтын орчин, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тавилга эд хогшлын хангамж сайжирсан; - Сонсогч, оюутан нарын дадлагын хичээл явуулах сургалт дадлагын төвтэй болсон - Суралцагч, төгсөгчид тодорхой хандив өгдөг нь сургалтын орчин нөхцлийг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэхэд зохих байдлаар нөлөөлсөн;	- Төсвийн орлогын эх үүсвэрийн нэг хэсэг болох өөрийн үйл ажиллагааны орлого нь төлөвлөгөөнөөс давсан тохиолдолд буцаан зарцуулах эрх зүйн зохицуулалтын шийдвэрийг 2017 онд гаргасан нь төсөвт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдаж байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүрэх; - Хичээлийн 1,2-р байр, биеийн тамирын заал, зоогийн газрын барилга, автомашинууд хуучирсан ашиглалтын зардал их, зориулалтын гражийн байргүй; - Төсөвт урсгал засвар, эд хогшил худалдан авахад зарцуулах хөрөнгө бага хувийг эзэлдэг; - Багш, алба хаагч, сонсогч оюутан нарын сурч, ажиллах, амьдрах орчин бүрэн бүрдээгүй; - Сонсогч, оюутны 90 гаруй хувь нь 18-21 насны эрэгтэйчүүд тул зарим эд хогшлын эвдрэл, гэмтэлд зохих хэмжээгээр нөлөөлдөг

Гадаад орчны шинжилгээ	
Боломж	Бэрхшээл
- Төсөвт зардлыг улсын төсвөөс 100% санхүүжүүлдэг бодитой болгох - Улсын төсвийн хөрөнгөөр хүчний хичээл явуулах, бэлтгэл хийх спортын ордон барьж ашиглалтанд оруулах - Сургалтын орчин нөхцөл, материаллаг баазыг гадаад, дотоодын их, дээд сургуулиудын жишигт хүргэх хүрээнд дээд шатны байгууллагын зүгээс сүүлийн жилүүдэд анхаарч санхүүгийн нэмэлт хөрөнгийг хуваарилах болсон - Их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны хүрээнд дотоодоос хандив, тусламж, дэмжлэг авах боломжтой	- Цэрэгжисэн байгууллага гэсэн шалтгаанаар олон улсын зарим байгууллагын дэмжлэг авах, төсөл хэрэгжүүлэх, сургалтанд хамрагдах боломж хязгаарлагдмал. - Мэдээлэл дутмаг орчинд ажиллаж буйн улмаас оюуны сүлжээ үүсгэх, улмаар давуу талаараа хорших, хамтран ажиллах, үйл ажиллагаагаа нэгтгэх, туршлага солилцох боломж хязгаарлагдмал; - Өрсөлдөөн дутмаг учир хөгжил удаашрах хандлагатай - Гадаад хамтын ажиллагаа бүрэн хөгжөөгүй

Тус их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, эдийн засгийн хувьд жилээс жилд өсөн бэхжиж сургалтын материаллаг бааз өргөжиж, сургалтын орчин сайжирч, сургалт явуулах таатай нөхцлийг бүрдүүлж байна.

Цаашид тавих зорилт

Их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн шинэчилж, ашиглагдаж буй үндсэн хөрөнгийг нэг бүрчлэн баркоджуулах, хөрөнгөнд бүртгэлээр болон биетээр тавих хяналтыг сайжруулах, хадгалалт, хамгаалалтын орчинг боловсронгуй болгох, **үргүй зардлыг багасгах, хэмнэлттэй, үр дүнтэй ажиллах**

САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА